



**ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/27

Улиастай

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Чадварлаг эмч” арга хэмжээг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд Эмч, эмнэлгийн ажилтаны эрдэм шинжилгээ судалгааны ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, олон улсад нэр хүнд бүхий web of science scopus -д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн судлаач эмч, эмнэлгийн ажилтаныг урамшуулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Ж.Должинсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



М.ҮРЖИНХАНД

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
07 дугаар сарын 08 өдрийн 1/27 дугаар
тушаалын хавсралт



“ЧАДВАРЛАГ ЭМЧ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЭМЧ, ЭМНЭЛГИЙН
АЖИЛТАНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖЛЫН УР ЧАДВАРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ, ОЛОН УЛСАД НЭР ХҮНД БҮХИЙ Web of science Scopus -д
БҮРТГЭЛТЭЙ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛД ӨГҮҮЛЭЛ ХЭВЛҮҮЛСЭН
СУДЛААЧ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН АЖИЛТАНЫГ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн чиглэлээр 37 зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхээр дэвшүүлж, эмнэлгийн эмч мэргэжилтнийг тасралтгүй хөгжүүлэн, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд дэвшилтэд технологийг нэвтрүүлэн эмч мэргэжилтнийг мэргэжлийн өндөр түвшинд бэлдэх зорилго бүхий “Чадварлаг эмч” арга хэмжээг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дэвшүүлсэн нэг зорилт нь аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтаны эрдэм шинжилгээ судалгааны ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, судлаач эмч нараас олон улсад нэр хүнд бүхий Web of science Scopus-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн эмч, эмнэлгийн ажилтаныг урамшуулах заалтыг оруулсан бөгөөд энэхүү зорилт нь Чадварлаг эмч арга хэмжээний 1 дүгээр зорилтын 1.6-д заасан байна.

Цаашид эмнэлгийн ажилтны эрдэм шинжилгээ судалгааны ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, судлаач эмч нарыг дэмжих, урамшуулан ажиллах бөгөөд хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган ажиллана.

Хоёр. Баримтлах нийтлэг зарчим

2.1. Журмаар “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд судлаач эмч, эмнэлгийн ажилтныг урамшуулах дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

2.2. Монгол улсын үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрт үндэслэгдсэн байна.

2.3. Ил тод, нээлттэй байна.

2.4. Бодитой, үр дүнтэй байна.

2.5. Шударга, хариуцлагатай байна.

2.6. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд шалгуурын дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалыг бүрдүүлэн ажлын хэсэгт заасан хугацаанд нь ирүүлсэн байна.

Гурав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

3.1. Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлөөр сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

3.2. Эрүүл мэндийн газар нь 2024 оны 6 дугаар сарын эхний 15 хоногт багтаан материалыг хүлээн авна.

3.3. Материалыг хүлээн авч ажлын 3 өдөрт багтаан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.4. Шалгуур үзүүлэлтийг хангасан эмч, эмнэлгийн ажилтанд 10,000.000 (арван сая) төгрөгийн дэмжлэгийг үзүүлнэ.

3.4. Шалгаруулалтын үр дүнгээр урамшуулах дэмжлэг үзүүлэх, олгох үйл ажиллагааг аймгийн Эрүүл мэндийн газар нь хариуцан зохион байгуулна.

Дөрөв. Эрүүл мэндийн ажилтан дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байх

4.1. Аймгийн эрүүл мэндийн салбарт 5-аас дээш жил тасралтгүй ажилласан байх, цаашид тогтвор суурьшилтай ажиллах;

4.2. Судлаач эмч эмнэлгийн мэргэжилтэн нь эрдэм шинжилгээ судалгааны ажлын сэдэв аргачлалаа АШУҮИС-н бүрэлдэхүүн сургууль болон харьяа тэнхимийн эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулсан хурлын тэмдэглэлтэй байх;

4.3. Судлаач эмч нь олон улсад нэр хүнд бүхий Web of science Scopus-д бүртгэлтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байх;

4.4. Хэвлүүлсэн өгүүлэл нь олон улсад нэр хүнд бүхий Web of science Scopus-д бүртгэлтэй (IF 2.5) импакт фактор 2.5-с дээш сэтгүүлд 1-р зохиогчоор хэвлүүлсэн бүтээлийг биет байдлаар болон тухайн бүтээлийн хэвлэгдсэн болохыг нотлох бөгөөд сэтгүүлийн web site-н хаяг, өргөтгөлийг харуулах;

4.5. Судалгааны үр дүнг дэлхийн шинжлэх ухаан мэдээллийн сан болох Genbank-д 1-р зохиогчоор бүртгүүлсэн бүртгэлийн дугаарыг баталгаажуулсан байх;